

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2025/014/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: Ж.Баясгалан

Утас: 70362442 Цахим хаяг: Bayasgalanj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|--|----|
| 1. Аудитын дүгнэлт..... | 3 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл | 5 |
| 3. Санхүүгийн тайлангийн тодруулга | 10 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа..... | 10 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 11 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт..... | 11 |
| 4. Аудитын тайлан..... | 19 |
| 4.1 Ерөнхий зүйл..... | 19 |
| 4.2 Материаллаг байдал..... | 20 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт | 20 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 20 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 21 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 22 |
| 5. Аудитын илрүүлэлт | 17 |
| 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл..... | 20 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|-------------|--|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| НББОУС | Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| ОНЕО | Орон нутгийн ерөнхий орлого |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ТБОНӨХБАУХА | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил , үйлчилгээ худалдан авах |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ТЗШ | Тусгай зориулалтын шилжүүлэг |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ХНХС | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд |
| ХХААХҮС | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХХС | Хоршоог хөгжүүлэх сан |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № МА-2025/04/НД-СТД-772
танай _____-ны № _____-т

ОРХОН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Г.БААСАНСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны үйл ажиллагаанд 1,917,541.3 мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 87.0 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 13.0 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

ЗДТГ нь төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг буюу өөрийн үйл ажиллагааны орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэлгүйгээр хэт багаар буюу 629.9 мянган төгрөгөөр төлөвлөж батлуулсан бөгөөд гүйцэтгэлээр төлөвлөгөөнөөс давсан 1,290.1 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд авч зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|----------|--|------------------------|------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 461,387.7 | 663,575.6 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 215,220.4 | 525,227.3 |
| 33 | АВЛАГА | 211,295.5 | 101,867.3 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 34,871.7 | 36,481.0 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,755,301.1 | 3,062,786.2 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,755,301.1 | 3,062,786.2 |
| 39200 | Биет хөрөнгө | 2,731,304.2 | 3,038,789.3 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 23,996.9 | 23,996.9 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 3,216,688.8 | 3,726,361.7 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 2,650.9 | 39,474.2 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 2,650.9 | 39,474.2 |
| 41300 | Өглөг | 2,650.9 | 39,474.2 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 3,214,037.9 | 3,686,887.5 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,214,037.9 | 3,686,887.5 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 262,048.7 | 262,048.7 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 2,826,361.0 | 3,299,210.7 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 125,628.1 | 125,628.1 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 3,216,688.8 | 3,726,361.7 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|-----------|--|------------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,501,011.40 | 2,583,735.6 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 509,575.10 | 802,102.6 |
| 110 | Орлогын албан татвар | 265,239.10 | 385,355.3 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 283,378.40 | 425,950.5 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (18,139.20) | (40,595.2) |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 161,734.40 | 157,176.2 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 82,601.60 | 259,571.1 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 967,497.40 | 621,577.9 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 967,497.40 | 621,577.9 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,023,938.90 | 1,160,055.0 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,346,586.20 | 1,633,502.5 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,315,111.70 | 1,609,552.9 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,299,344.10 | 1,536,035.2 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 415,314.80 | 595,753.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 53,831.60 | 75,301.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 35,280.60 | 425,997.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 42,464.80 | 51,385.5 |
| 2105 | Нормативт зардал | 274 | 0.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,623.90 | 38,112.5 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,705.00 | 5,270.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 392,252.10 | 43,675.2 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 344,597.20 | 300,540.3 |

| | | | |
|-----|--|---------------------|------------------|
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 15,767.60 | 73,517.7 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 31,474.60 | 23,949.6 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 1,154,425.20 | 950,233.1 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 512,715.80 | 468,562.1 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 641,709.40 | 481,671.0 |

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|------|--|--|-----------------------|------------------------|
| 1 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,575,328.4 | 0.0 | 2,575,328.4 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (3,000.0) | 0.0 | (3,000.0) |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,572,328.4 | 0.0 | 2,572,328.4 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 641,709.4 | 0.0 | 641,709.4 |
| 10 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,214,037.9 | 0.0 | 3,214,037.9 |
| 11 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 3,214,037.9 | 0.0 | 3,214,037.9 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (8,821.4) | 0.0 | (8,821.4) |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,205,216.5 | 0.0 | 3,205,216.5 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 481,671.0 | 0.0 | 481,671.0 |
| 20 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,686,887.5 | 0.0 | 3,686,887.5 |

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|------|---|------------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 1,708,278.50 | 2,185,850.1 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 509,575.10 | 802,102.6 |
| 110 | Орлогын албан татвар | 265,239.10 | 385,355.3 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 283,378.40 | 425,950.5 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (18,139.20) | (40,595.2) |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 161,734.40 | 157,176.2 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 82,601.60 | 259,571.1 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 8,775.70 | 19,435.2 |
| 1181 | Газрын төлбөр | 41,405.60 | 206,419.0 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 32,420.30 | 33,716.9 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 174,764.50 | 195,873.7 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 174,764.50 | 195,873.7 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,023,938.90 | 1,187,873.8 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,044,312.70 | 1,377,738.6 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,044,312.70 | 1,377,738.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,028,545.10 | 1,304,220.9 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 415,087.80 | 594,810.3 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 54,049.60 | 75,649.8 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 35,280.60 | 425,997.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 41,261.90 | 49,517.0 |
| 2105 | Нормативт зардал | 274 | 0.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,623.90 | 38,112.5 |
| 2107 | Томиллолт, зочны зардал | 5,705.00 | 5,144.0 |

| | | | |
|------|---|---------------------|--------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 393,358.70 | 44,770.2 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 73,903.70 | 70,219.4 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 15,767.60 | 73,517.7 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 663,965.80 | 808,111.5 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 732,618.70 | 498,104.7 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 732,618.70 | 498,104.7 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 732,618.70 | 498,104.7 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (732,618.70) | (498,104.7) |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | (121,000.00) | 0.0 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 121,000.00 | 0.0 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | (189,653.00) | 310,006.8 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 404,873.40 | 215,220.4 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 215,220.40 | 525,227.3 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Дүн | Хувь |
|------|--|--------------------|--------------------|--------------------|-------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,064,998.8 | 1,795,817.5 | (269,181.3) | 87.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,434,918.9 | 1,303,305.8 | (131,613.1) | 90.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,321,671.7 | 1,229,788.1 | (91,883.6) | 93.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 636,272.8 | 594,020.6 | (42,252.2) | 93.4 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 87,592.3 | 75,649.7 | (11,942.6) | 86.4 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 449,662.0 | 425,997.6 | (23,664.4) | 94.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 42,174.0 | 40,608.3 | (1,565.7) | 96.3 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 38,680.6 | 33,252.5 | (5,428.1) | 86.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,240.0 | 5,144.0 | (96.0) | 98.2 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 26,600.0 | 20,063.2 | (6,536.8) | 75.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,450.0 | 35,051.9 | (398.1) | 98.9 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 113,247.2 | 73,517.6 | (39,729.6) | 64.9 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 113,247.2 | 73,517.6 | (39,729.6) | 64.9 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 518,022.3 | 492,511.6 | (25,510.7) | 95.1 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 112,057.6 | - | | |

| | | | | | |
|-----|---|--------------------|--------------------|--------------------|-------------|
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,064,998.8 | 1,917,541.6 | (147,457.2) | 92.9 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,917,740.4 | 1,804,621.3 | (113,119.1) | 94.1 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 147,258.4 | 112,920.2 | (34,338.2) | 76.7 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 55,078.8 | 55,078.8 | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 176,802.9 | 176,802.9 | |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|------|---|------------|-----------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 80,092.7 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 80,092.7 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 80,025.7 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 789.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 8,908.6 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 4,860.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 25,400.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 40,067.4 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 67.0 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 67.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | - |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | | - |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 80,092.7 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 80,092.7 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орхон сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Төрийн албыг бэхжүүлж, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээг төлөвшүүлэн, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлийг бүх талаар дэмжсэн хүний эрхийг дээдэлсэн авлигагүй, ХАРИУЦЛАГАТАЙ, ШУУРХАЙ, ТЭГШ, НЭЭЛТТЭЙ төрийн үйлчилгээ бүхий сум байна” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төсвийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан ил тод нээлттэй төлөвлөн хуваарилж, салбарын хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөв, санхүүгийн менежментийг сайжруулж, аймгийн эдийн засгийг жил бүр тогтвортой өсгөх бодлогыг хэрэгжүүлнэ.

- Эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, газар тариалан, эрчимжсэн мал ахуй, аялал жуулчлал, үйлдвэрлэлийн салбарт түшиглэсэн эдийн засгийн цогцолбор бүс нутаг болно.
- Эдийн засгийн тогтвортой өсөлт өрх бүрдээ хүрсэн, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй, аялал жуулчлалын салбарт түшиглэсэн эдийн засгийн цогцолбор бүс нутаг болно
- Сум бүр үйлдвэрлэгч байж, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлнэ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг баталсан,*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт нь оновчтой, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

2024 онд тус ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй боловч ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод хяналт, шалгалтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналт, шалгалтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон сумын ТТЗ-ийн 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Орхон сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Түшиг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 509,672.9 мянган төгрөгөөр буюу 13.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | /мянган төгрөгөөр/ | | |
|--|--------------------|--------------------|------------------|
| | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 215,220.4 | 525,227.3 | 310,006.9 |
| Авлага | 211,295.5 | 101,867.3 | (109,428.2) |
| Бараа материал | 34,871.7 | 36,481.0 | 1,609.3 |
| Үндсэн хөрөнгө | 2,755,301.1 | 3,062,786.2 | 307,485.1 |
| Нийт хөрөнгө | 3,216,688.8 | 3,726,361.7 | 509,672.9 |
| Өр төлбөр | 2,650.9 | 39,474.2 | 36,823.3 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 3,214,037.9 | 3,686,887.5 | 472,849.6 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 3,216,688.8 | 3,726,361.7 | 509,672.9 |

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгт нь өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо бөгөөд өөрчлөлтийг тус бүрээр нь харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 215,220.4 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 525,227.3 мянган төгрөг болж, 310,006.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|----------------------------|------------------|------------------|------------------------|
| Банканд байгаа бэлэн мөнгө | 215,220.4 | 525,227.3 | 310,006.9 |
| Төрийн сангийн харилцах | 215,220.4 | 525,227.3 | 310,006.9 |
| Дүн | 215,220.4 | 525,227.3 | 310,006.9 |

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлд ОНХО-ын дансны 348,424.3 мянган төгрөгийн, ХХС-ийн дансны 164,900.4 мянган төгрөг, ОНХС-ийн дансны 11,902.5 мянган төгрөгийн үлдэгдэл тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 211,295.5 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 101,867.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 109,428.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|------------------------|------------------|------------------|------------------------|
| Зээлийн авлага | 204,704.4 | 98,858.9 | (105,845.5) |
| Зээлийн хүүгийн авлага | 6,591.1 | 3,008.4 | (3,582.7) |
| Дүн | 211,295.5 | 101,867.3 | (109,428.2) |

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэлд ХХС-ийн зээлийн 101,867.3 мянган төгрөгийн авлага тайлагнагдсан байна. Энэ нь ХХС-ийн зээлээс төлөлт хийгдсэнтэй холбоотой байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 34,871.7 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 36,481.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,609.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|------------------------------|-----------------|-----------------|------------------------|
| Түүхий эд материал | 287.0 | 287.0 | 0.0 |
| Тусгай зориулалттай материал | 287.0 | 287.0 | 0.0 |
| Хангамжийн материал | 34,584.7 | 36,194.0 | 1,609.3 |
| Бичиг хэргийн материал | 1,008.1 | 981.0 | (27.1) |
| Аж ахуйн материал | 14,795.3 | 15,267.1 | 471.8 |
| Барилгын материал | 41.0 | 121.2 | 80.2 |
| Түлш, шатах тослох материал | 159.0 | 1,243.4 | 1,084.4 |
| Хүнсний материал | 1,166.7 | 1,166.7 | 0.0 |
| Бусад хангамжийн материал | 17,414.6 | 17,414.6 | 0.0 |
| Дүн | 34,871.7 | 36,481.0 | 1,609.3 |

Орхон сумын ТТЗ нийт 530,009.3 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 528,400.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,755,301.1 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 3,062,786.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 307,485.10 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|----------------------------------|--------------------|--------------------|------------------------|
| Биет хөрөнгө | 2,731,304.2 | 3,038,789.3 | 307,485.10 |
| Барилга, байгууламж, орон сууц | 1,771,679.4 | 2,194,897.3 | 423,217.90 |
| Хуримтлагдсан элэгдэл | (191,600.8) | (267,269.7) | (75,668.90) |
| Авто-тээврийн хэрэгсэл | 239,707.1 | 260,457.1 | 20,750.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (106,100.3) | (133,117.4) | (27,017.10) |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 178,564.7 | 234,381.4 | 55,816.70 |
| Хуримтлагдсан элэгдэл | (72,643.4) | (90,275.6) | (17,632.20) |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 54,010.2 | 54,010.2 | 0.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (32,071.0) | (36,376.0) | (4,305.00) |
| Зам, гүүрийн байгууламж | 578,283.5 | 578,283.5 | 0.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (308,151.4) | (355,804.0) | (47,652.60) |
| Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 14,000.0 | 14,000.0 | 0.00 |
| Бусад үндсэн хөрөнгө | 834,054.5 | 898,545.0 | 64,490.50 |
| Хуримтлагдсан элэгдэл | (228,628.3) | (313,142.6) | (84,514.30) |
| Ном | 200.0 | 200.0 | 0.00 |
| Биет бус хөрөнгө | 23,996.9 | 23,996.9 | 0.00 |
| Программ хангамж | 3,950.0 | 3,950.0 | 0.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (2,809.4) | (2,809.4) | 0.00 |
| Бусад биет бус хөрөнгө | 27,192.3 | 27,192.3 | 0.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (4,336.0) | (4,336.0) | 0.00 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 2,755,301.1 | 3,062,786.2 | 307,485.10 |

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 307,485.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 158,428.4 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, ОНХС-аас 450,854.1 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, бусад хөрөнгө 172,413.6 мянган төгрөгийн тавилга, эд хогшлоор нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөр данс 39,474.2 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|-----------------------------|-------------------|--------------------|---------------------------|
| Ажилчидтай холбогдсон өглөг | 326.9 | 2,767.0 | 2,440.1 |
| Байгууллагад төлөх өглөг | 1,295.2 | 36,707.2 | 35,412.0 |
| Дүн | 1,622.1 | 39,474.2 | 37,852.1 |

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 39,474.2 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнасан байна. Үүнд:

- ИТХ-ын НДШ, ХХОАТ-ын өглөг 2,440.1 мянган төгрөгийн,
- Нийгмийн даатгалын программын алдаанаас шалтгаалан үүссэн ЗДТГ-ын албан хаагчидтай холбоотой НДШ-ийн 326.9 мянган төгрөгийн,
- Өмнөх онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэх хогны машиныг нийлүүлээгүй аж ахуйн нэгжээс шүүхийн шийдвэрээр нөхөн төлүүлэх / ЗДТГ-аас ОНХС-д / 36,707.2 мянган төгрөгийн өр төлбөр тусгагдсан байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,214,037.9 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 3,686,887.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 472,849.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|--|--------------------|--------------------|---------------------------|
| Засгийн газрын оруулсан капитал | 3,214,037.9 | 3,686,887.5 | 472,849.6 |
| Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 262,048.7 | 262,048.7 | |
| Хуримтлагдсан үр дүн | 2,826,361.0 | 3,299,210.7 | 472,849.6 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 125,628.1 | 125,628.1 | |
| Дүн | 3,214,037.9 | 3,686,887.5 | 472,849.6 |

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 472,849.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн хуримтлагдсан үр дүн өссөнөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн татварын болон татварын бус орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын 2024 оны орон нутгийн төсөв батлах тухай 2024 оны 61 дүгээр тогтоолоор тайлант онд 636,075.7 мянган төгрөгийн татварын орлого, 80,000.0 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 885,055.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 23.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №8. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|----------------------------------|------------------|------------------|------------------|--------------|
| Цалин, түүнтэй адилтгах | 200,000.0 | 273,331.6 | 73,331.6 | 136.7 |
| Үйл ажиллагааны орлого | 40,279.3 | 138,820.2 | 98,540.9 | 344.6 |
| Хөрөнгийн орлого | 18,775.6 | 10,806.1 | (7,969.5) | 57.6 |
| Хөрөнгө борлуулсны орлого | 6,295.8 | 2,992.5 | (3,303.3) | 47.5 |
| ХХОАТ-ын буцаан олголт | (40,595.3) | (40,595.2) | 0.1 | 100.0 |
| үл хөдлөх эд хөрөн албан татвар | 5,800.0 | 7,042.3 | 1,242.3 | 121.4 |
| Бууны албан татвар | 1,000.0 | 1,140.0 | 140.0 | 114.0 |
| Малд ногдуулах албан татвар | 166,000.0 | 148,993.9 | (17,006.1) | 89.8 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 5,000.0 | 8,093.0 | 3,093.0 | 161.9 |
| Түгээмэл тархацтай АМАТ | 5,000.0 | 10,667.2 | 5,667.2 | 213.3 |
| Хог хаягдлын үйлчилгээний төлбөр | 2,000.0 | 675.0 | (1,325.0) | 33.8 |
| Газрын төлбөр | 174,950.3 | 190,418.9 | 15,468.6 | 108.8 |
| Дуудлага худалдаа | 16,000.0 | 16,000.0 | - | 100.0 |
| Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 570.0 | 240.0 | (330.0) | 42.1 |
| Байгалийн ургамлын НАТөлбөр | 35,000.0 | 33,476.9 | (1,523.1) | 95.6 |
| Нийт татварын орлого | 636,075.7 | 802,102.4 | 166,026.7 | 126.1 |
| Торгуулийн орлого | 55,000.0 | 23,779.0 | (31,221.0) | 43.2 |
| Бусад орлого | 25,000.0 | 59,174.4 | 34,174.4 | 236.7 |
| Татварын бус орлого | 80,000.0 | 82,953.4 | 2,953.4 | 103.7 |
| Нийт орлого | 716,075.7 | 885,055.8 | 168,980.1 | 123.6 |

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелсэн нь:

- Цалин, түүнтэй адилтгах орлого давж биелсэн нь төрийн албан хаагчдын цалин 10-20 хувь, орон нутгийн нэмэгдэл цалин 30 хувь өссөнтэй холбоотой
- “Эрдэнэс таван толгой” ХК хувьцааны ногдол ашиг тараасантай холбоотой ХХОАТ-ын дүн нэмэгдсэн,
- Бууны албан татвар өссөн нь цагдаагийн байгууллагатай хамтран урд оны өр барагдуулж ажилласантай холбоотой,
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтын төлбөр өссөн нь байгаль хамгаалагч шинээр ажилд орсноор байгалийн түгээмэл тархац ашигт малтмалын зөвшөөрөл олгох боломжтой болж, элс хайрга авах аж ахуйн нэгж иргэдийн тоо өссөн.
- Газрын төлбөрийн орлого өссөн нь газрын даамалтай хамтран газрын төлбөрийг биелүүлэн урд оны өрийг барагдуулах ажил зохион байгуулсан тул 8.8 хувиар давуулан биелүүлсэн,
- Бусад орлого өссөн нь нэр заагдаагүй бусад орлогын гүйцэтгэлийн хяналт, гүйцэтгэлийг сайжруулсантай холбоотой / төрийн албан хаагчийн байрны түрээс, фондны өвс тэжээлийн борлуулалт, ухаалаг худгийн системийн орлого, гэх зэрэг.../

Төсвийн төлөвлөгөө тасарсан орлого:

- Хөрөнгийн орлого, хөрөнгө борлуулсны орлого, малд ногдуулах албан татвар зэрэг орлогууд тасарсан нь тус сумын татварын улсын байцаагч амаржсаны дараах чөлөө авч, орлого бүрдүүлэлтэд хяналт тавиагүйгээс,

- Торгуулийн орлого буурсан нь Цагдаагийн газраас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх аян зохион байгуулсантай холбоотой зөрчил гаргах иргэдийн тоо буурсан,

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зарлагыг тус бүр 2,010,728.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Орхон сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 65 дугаар тогтоолоор төсвийн орлогыг 716,075.7 мянган төгрөгөөр, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 853,818.0 мянган төгрөгөөр, ОНХС-аас олгох шилжүүлгийг 281,962.0 мянган төгрөгөөр, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтийг 111,923.0 мянган төгрөгөөр, сумын төсвийн урьд оны үлдэгдлээс 43,949.6 мянган төгрөг, төсвийн байгууллагын өөрийн орлогоос 3,000.0 мянган төгрөг зэрэг нийт **2,010,728.3** мянган төгрөгөөр баталсан байна

- **Тодотгол:**

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор аймгийн 2024 оны төсвийг тодотгож аймгаас олгох санхүүгийн дэмжлэгийг нийт 785,497.7 мянган төгрөг болгон баталсантай холбоотой сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 78 дугаар тогтоолоор төсөвт өөрчлөлт оруулан **2,064,998.8** мянган төгрөг болгон эцэслэн баталсан.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Нийт зардлын 785,497.7 мянган төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, 716,075.7 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 119,742.2 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 114,980.6 мянган төгрөгийг ХХС-ийн олгосон зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс, ОНХС-аас 296,424.8 мянган төгрөг, ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс 31,647.9 мянган төгрөг, 629.9 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,795,817.5** мянган төгрөг буюу 87 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсөв болон тогтмол зардлын санхүүжилтийг хэмнэснээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т *“нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна”* гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн ЗДТГ-аас 3,202.9 мянган төгрөгийн, Статистикийн хэлтсээс 1,038.5 мянган төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого

1,920.0 мянган төгрөг болон бусад 73,931.3 мянган төгрөг зэрэг нийт 80,092.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг дараах зардлуудад зарцуулсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 789.7 мянган төгрөг,
- Хангамж, бараа материалын зардалд 8,908.6 мянган төгрөг,,
- Эд хогшил, урсгал засварын зардалд 4,860.0 мянган төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 25,400.0 мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардалд 40,067.4 мянган төгрөг,
- Урсгал шилжүүлгийн зардал 67.0 мянган төгрөг гэх мэт.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд Орхон сумын ОНХО-ын хөрөнгөөр гүйцэтгэхээр баталсан 468,332.1 мянган төгрөгийн 13 төсөл, арга хэмжээ, ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэхээр баталсан 23,949.6 мянган төгрөгийн 2 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зэрэг нийт 15 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг урилгыг tender.gov.mn цахим хуудсанд бүрэн байршуулсан байна.

Хүснэгт 10. Орхон сумын 2024 оны худалдан авах ажиллагааны тайлан:

/мянган төгрөгөөр/

| Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр | Нийт төсөл, арга хэмжээ | | Үүнээс | | | | | |
|------------------------------------|-------------------------|------------------|-----------|-------------------|--------------------|------------------|----------|------------------|
| | | | ШХА | | Харьцуулалтын арга | | НТШ | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Сумын ОНХС | 13 | 494,072.7 | 10 | 162,368.2 | 2 | 58,410.1 | 1 | 273,294.4 |
| Сумын ОНХО | 2 | 23,949.6 | 2 | 23,949.6 | | | | |
| Дүн | 15 | 492,281.7 | 12 | 160,807.21 | 2 | 58,410.10 | 1 | 273,294.4 |

Эх сурвалж: tender.gov.mn

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон сумын ТТЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баясгалан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон сумын ТТЗ-ийн 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/76 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тус ТТЗ-ийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,354,971.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 13,549.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажилласан байна. Үүнд:

- *Батлагдсан төсвийг 37 хувиар хэмнэсэн,*
- *Албан хаагчдын гар утасны зардал гаргаагүй,*
- *сонин хэвлэл захиалаагүй гэх мэт...*

2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн нийцэлтэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ЗДТГ-аас видео контент хийлгэхээр “Монголын баялаг өв соёл ХХК”-тай гэрээ байгуулан **4,879.6** мянган төгрөгийн төлбөр шилжүүлсэн боловч гэрээт ажлыг хүлээн аваагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага өгөх.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 10. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдал

| <i>/мянган төгрөгөөр/</i> | | | | | |
|---------------------------|------------------------------|-----------------|------------|-------------------|-----------------|
| д/д | Байгууллагын нэр | Мэдээлбэл зохих | Мэдээлсэн | Хугацаа хоцроосон | Огт мэдээлээгүй |
| 1 | Төсвийн төвлөрүүлэн захирагч | 168 | 150 | 18 | - |
| 2 | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 171 | 159 | 12 | - |
| 3 | Засаг даргын Тамгын газар | 171 | 158 | 13 | - |
| | Нийт дүн | 510 | 467 | 43 | - |

Эх сурвалж: www.shilendans.gov.mn

ТТЗ болон харьяа байгууллагууд нь мэдээлбэл зохих 510 мэдээллээс 467 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 43 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Албан шаардлага: Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 171 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн аудитаар хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 38,670.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 20,814.0 мянган төгрөгийн 4 зөрчлийг арилгах албан шаардлага, 17,856.0 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитаар | | Биелэлт | | |
|-----------------|----------------|-----------------|----------|-----------------|--------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 4 | 20,814.0 | 4 | 20,814.0 | 100.0 |
| Зөвлөмж | 2 | 17,856.0 | 2 | 17,856.0 | 100.0 |
| Нийт дүн | 6 | 38,670.0 | 6 | 38,670.0 | 100.0 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **7,138.7** мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3,256.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 3,881.8 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Сумын ЗДТГ:

Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг үндэслэн орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчдад олгосон урамшууллаас ХХОАТ-ыг суутгаагүй байна. Үүнд:

- ЗДТГ нь 3 албан хаагчид олгосон 23,815.2 мянган төгрөгийн урамшууллаас **2,381.5** мянган төгрөг,
- ИТХ нь 1 албан хаагчид олгосон 8,754.9 мянган төгрөгийн урамшууллаас **875.4** мянган төгрөг.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно”, 6.3.1: “... урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 22 дугаар зүйлийн 22.1 дэх “Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө” 22.1.1: “хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр,

Шийдвэрлэсэн нь: ХХОАТ-ыг нөхөн суутгаж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч:

1. ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс **1,441.7** мянган төгрөгийг жил бүр давтагдан гардаг, төлөвлөх боломжтой, тохижилт үйлчилгээний зардал буюу нохой устгахад зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор баталсан *“Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”*-ын 3.1 дэх *“Нөөц хөрөнгийг зарцуулах тухай Засаг даргын шийдвэрийн төсөл нь дор дурдсан шаардлагыг хангасан байна: 3.1.2: урьдчилан төлөвлөх боломжтой....зардал ... ”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДНХ-ийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй давтан гаргасан буюу шилэн дансны 43 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх *“Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”*, 4.1.3 дахь *“Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”*, 6 дугаар зүйлийн 6.1 дэх *“Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх,

Сумын ИТХ:

Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас **2,440.1** мянган төгрөгийн НДШ, ХХОАТ өр үүсгэсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, 6.4.8 дахь *“Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгалгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----|--------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулсан | | залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Дүн | | | | | | | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|------------------|-------------|----------------|---------------|----------------|-----------------|----------------|---------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ТТЗ | 1 | 1,441.7 | | | 1 | 1,441.7 | | |
| ЗДТГ | 2 | 2,381.5 | 1 | 2,381.5 | | | | |
| ИТХ | 2 | 3,315.5 | 1 | 875.4 | 1 | 2,440.1 | | |
| Нийт дүн | 5 | 7,138.7 | 2 | 3,256.9 | 3 | 3,881.8 | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|----------------|---------------|-----|-----------------|----------------|----------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд 43 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | | | | 1 | | | |
| Дүн | 1 | | | | 1 | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| видео контент хийлгэсэн. | 1 | 4,879.6 | | | 1 | 4,879.6 | | |
| Дүн | 1 | 4,879.6 | | | 1 | 4,879.6 | | |
| Нийт дүн | 2 | 4,879.6 | | | 1 | 4,879.6 | 1 | |